Монголын Барилгын Үндэсний Ассоциаци

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
Монгол Улс, Улаанбаатар 15141, Чингэлтэй дүүрэг,
5 дугаар хороо, Самбуугийн гудамж 24,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот
Утас: + (976) 7011 1515
Утас: + (976) 7016 5055, + (976) 7018 5055
И-мэйл: info@mnca.mn, Веб: www.mnca.mn

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ
ТАНАА

____ 2021.01.08 ____№____21/01_____

Мэдэгдэл хүргүүлэх тухай

ЭРХЭМ ХҮНДЭТ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ

Таны энэ өдрийн амар амгаланг айлтгаж, ажил үйлсэд нь амжилт хүсэн мэндчилье.

Барилга, бүтээн байгуулалтын нийт бизнес эрхлэгчид, салбарын мэргэжлийн төрийн бус байгууллагууд болон манай Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ-ын нийт гишүүн байгууллагууд нэгдэж Монгол Улсын Засгийн газрыг улс орон даяар үүсээд байгаа цар тахлаас ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаа хамгаалах, урьдчилан сэргийлэх, бодитоор дэмжлэг үзүүлэн ажиллах онц шаардлага байгаа тухай мэдэгдлийг хүргүүлж байна.

Монгол Улсын УИХ нь энэ 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг баталж, энэ хуулийн 7 дугаар зүйлийн “Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний 7.1.2-т “*цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, хямралын эсрэг холбогдох санг арвижуулах зорилгоор жилийн батлагдсан төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх*” болон мөн зүйлийн 7.1.5-д *“цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх”,* түүнчлэн энэ хуулийн 10 дугаар зүйлийн “Төв банк болон арилжаан банкнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний 10.6-д *“Барилгын салбарын зээлийн чанар муудахаас сэргийлэх, ажлын байрыг хадгалах зорилгоор Төв банкнаас олгосон санхүүжилтийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн хэмжээгээр орон сууцны ипотекийн зээлийг үргэлжлүүлэн санхүүжүүлнэ”* болон мөн зүйлийн 10.7-д *“Ипотекийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр нийт 6 хүртэлх сараар хугацааг сунгах асуудлыг Засгийн газартай хамтран хэрэгжүүлнэ”* гэсэн заалтуудаар төсвийг зохицуулах эрхийг Засгийн газарт олгосон.

Гэсэн хэдий ч цар тахлын энэ хүнд үед Монгол Улсын Засгийн газар нь бодитой дэмжлэгийг хувийн хэвшилд олгохгүй байгаа тул дараах асуудлуудыг шийдвэрлэж өгөхийг бид хүсэж байна. Үүнд:

1. Төсвийн урсгал зардал, хөрөнгө оруулалтын зарцуулалтад хуулийн дагуу зохицуулалт хийх замаар **төсөвт дахин тодотгол хийх** (2021 оны улсын төсөвт 3.2 их наяд төгрөгийг төрийн албан хаагчдын цалингийн санд баталсан бөгөөд үүнээс 660 тэрбум төгрөгийг хувийн хэвшилд хөдөлмөр эрхэлж буй 770,000 гаруй хүмүүст цалингийн доод хэмжээгээр буюу 420,000 төгрөгөөр тооцож олгохыг хүсэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн "Хүний эрх, эрх чөлөө": 14 дүгээр зүйлийн 2-т заасан "*Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна"* гэсэн заалтаар төрийн албан хаагчдад 2020 оны 2 дугаар сараас хойш цалин хөлсийг нь олгож байгаатай ижилхэн хувийн хэвшилд хөдөлмөр эрхэлж буй хүмүүст ялгаварлан гадуурхахгүйгээр эрх тэгш, адилхан байдлаар цалингийн сангаас хуваарилж өгөх),
2. Хатуу хөл хорионд хоригдсоны улмаас ажиллаагүй ажилчдын ажилгүйдлийн сул зогсолтын болон даатгалын **нөхөн олговрыг** НДШ-ийн ирээдүйн орлогыг барьцаалан бонд босгох замаар хувийн хэвшилд олгож бизнесийн дэмжлэгийг үзүүлэх (бүх хувийн хэвшлийнхэн хэдэн мянган ажилтнуудын ажилгүйдлийн даатгалыг 0.2%-иар олон жил төлсөөр ирсэн),
3. Монгол банкны **бодлогын хүүг бууруулах буюу 3% болгох**, хадгаламжийн хүүг инфляцын түвшин хүртэл буулгах, ингэснээр аж ахуйн нэгж, байгууллагуудын бизнесийн зээлийн хүүг бууруулах,
4. НӨАТ-ыг **бууруулах буюу 5% болгох** зэрэг болно.

Манай барилга, бүтээн байгуулалтын салбарын бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгж, байгууллагууд, салбарын мэргэжлийн төрийн бус байгууллагуудаас гаргаж буй энэхүү мэдэгдлийг бид Тантай даруй биечлэн уулзаж аргачлалыг нь танилцуулах хүсэлтэй байгааг анхааралдаа авч дээр дурдсан асуудлыг шийдвэрлэн хамтран ажиллана гэдэгт гүнээ итгэж байна.

ХҮНДЭТГЭСЭН,

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Д.ЦЭРЭНЖИГМЭД

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД
МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО ТББ
МОНГОЛЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБОО ТББ
МОНГОЛЫН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧДЫН ХОЛБОО ТББ
МОНГОЛЫН БАРИЛГЫН ИНЖЕНЕРҮҮДИЙН ХОЛБОО ТББ
МОНГОЛЫН БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО ТББ
МОНГОЛЫН БАРИЛГЫН ТӨСӨВЧДИЙН ХОЛБОО ТББ
МОНГОЛЫН ӨРГӨН ТЭЭВЭРЛЭХ МАШИН ТӨХӨӨРӨМЖИЙН ҮНДЭСНИЙ ХОЛБОО ТББ
МОНГОЛЫН БАРИЛГЫН ИНЖЕНЕР ГЕОЛОГИЧДЫН ХОЛБОО ТББ